

К. Марксын мэндэлсэний 170 жилийн ойд

К. МАРКС БА ДОРНОДАХИН

Э. ПУНЦАГ

Шинжлэх ухааны Коммунизмын үндсийг тавигчид хүнд үйлдвэр хөгжсөн зөвхөн Өрнөд Европын хэдэн хөрөнгөтөн орон төдийгүй Дорно дахины колони ба хагас колони орнуудын нийгмийн хувьсгалын асуудлыг харилцан уялдуулж нэгтгэн дүгнэсэн үндсэн дээр социалист хувьсгалын онолын үндсийг боловсруулсан хосгүй гавьяат суу билэгтэн юм. К. Маркс Дорнод ахины дарлагдсан ард түмний үндэсний чөлөөлөх тэмцэлд ихээхэн анхаарал тавьж Энэтхэгт, мөн Хятадад явуулж байсан Английн бодлогын жишээн дээр Европын колончлогчдоос Ази, Африкийн ард түмнийг капиталын эрхшээлд атган захираад хайр найргүй дарлан мөлжиж байсны бүхий л судас шөрмөсийг илрүүлэн барьж, одоо болоод хэтийн үр дагаврыг нь онолын үүднээс тайлбарлажээ.

Шинжлэх ухааны онолчдын туурвиж бүтээж байсан XIX зуун бол бүхэлдээ капитализмын эрин байлаа. Гэвч агуу их сэтгэгч К. Маркс, Ф. Энгельс нар тухайн үедээ ирмүүн хөгжиж байсан капиталист үйлдвэрлэлийн аргыг материалист диалектикийн үүднээс нарийвчлан судалж түүний мөнх биш, шилжилтийн чанартай болох зүй тогтлыг илрүүлэн тунхагласан билээ. Энэ нь нийгмийн нэг формац нөгөөгөөр солигдох ёстой гэсэн үг бөгөөд К. Маркс, Ф. Энгельс нарын нийгмийг өөрчлөх улс төр-ангийн гол зарчим нь «Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!» гэдэг хүчирхэг лоозунд тусгалаа олж, коммунист, ажилчны хөдөлгөөн, үндэсний чөлөөлөх хөдөлгөөн зэрэг орчин үеийн гурван их хувьсгалт хүчний өрнөлт хөгжилтийн явцад биелэлээ олсоор байна. Чухамхүү энэхүү тэргүүн зэргийн шинжлэх ухаан болох Марксизмын ачаар Колони ба хагас Колони орнуудын ард түмний үндэсний чөлөөлөх тэмцэл дэлхийн хувьсгалт хүчний бүрэлдэхүүн хэсэг гэдгийг тэдгээр орны ард түмэн анх удаа сэхээрэх болсон юм.

К. Маркс, Ф. Энгельс, нар хоцрогдсон орнууд социализмд шилжиж болох замын тухай шинжлэх ухааны таамаглалаа бүр 1846—1848 оны үед дэвшүүлсэн байна. «Германы үзэл суртал», «Коммунизмын зарчим» зэрэг зохиолдоо Маркс, Энгельс нар Европод ялсан социалист хувьсгал дэлхийн бусад орнуудад ихээхэн нөлөө үзүүлэх бөгөөд тэдгээрийн хөгжлийн хуучин явцыг бүрмөсөн өөрчилж маш түргэтгэх тухай дурдаад «тэрхүү хувьсгал бол дэлхий дахины хувьсгал, тийм учраас дэлхий дахинаа тархах болно»¹ гэж заасан байна.

Гэхдээ Ази, Дорнод ахинд хувьсгал гараагүй буюу гарах нөхцөл бүрэлдээгүй нөхцөлд Европт хувьсгал ялахад ямар бэрхшээлтэйг К. Маркс ойлгож байсан бол Монгол, Перс, Энэтхэг, Египетчүүдтэй эс ойртвол Европ дахь социализм бат биш гэдгийг В. И. Ленин заан, тэмдэглэж байлаа.

Дорнодахинд Хятад, Энэтхэг мэт том орнуудад хэзээ нэгэн цагт тэртэй тэргүй гарах нийгмийн их хувьсгалын замыг Английн колончлол санаандгүй ойртуулсныг К. Маркс ихэд олзуурхаж Дорнодахины

хувьсгалыг зөгнөн талархаж байв. К. Маркс, Ф. Энгельс нар 1850 оны эхээр Лондонд байхдаа бичсэн «Олон улсын тоймдоо» Европын харги сууд мөдхөн Хятадын цагаан хэрэмд тулж очоод:

REPUBLIQUE CHINOIS LIBERTE,
EGALITE, FRATERNITE*

гэсэн хаягтай тулгарах ч билүү, яаж мэдхэв гэж тэмдэглэсэн нь ёсоор болж 1912 онд Хятадад олон мянган жил үе залгамжилсан эзэн хаант төр мөхөж оронд нь бүгд найрамдах улсыг тунхагласан билээ.* Ийнхүү харийн дарлалыг эсэргүүцсэн Хятадын ард түмний Тайпины бослого (1851 — 1864), Английн ноёрхолын эсрэг 1857 онд Энэтхэгийн Дели, Лакнау зэрэг олон хотуудад өрнөсөн сипай буюу цэргийн бослого Маркс, Энгельс нарын анхаарлыг татаж тэд өөрсдийн талархсан үзэл санааг Англи, Америк, Германы сонин хэвлэлүүдэд нийтлэгдсэн олон тооны өгүүлэлүүддээ илэрхийлж байжээ. Нийгмийн хувьсгалын тухай К. Марксын сургаал зөвхөн Европын бус, харин дэлхий нийтийн ач холбогдолтойг ойлгоход тэрээр «Энэтхэг дэх Британы эзэмшлийн үр дүн» гэдэг алдарт өгүүлэлдээ нутаг дэвсгэрийн хэмжээгээр Европоос багагүй энэ улс орныг цөлмөн хоосолж буй капиталын ноёрхлын тухайн үеийн үйлдвэрлэлийн систем, геологийн хувьсгал дэлхийн гадрагыг бий болгосон шиг шинэ ертөнцийн материаллаг нөхцөлийг буй болгож улмаар нийгмийн агуу их хувьсгалд хүргэх тухай² заасан байдаг нэгэн баримт ч хангалттай болно. Энэ бол Маркс Дорнодахины улс орны үйлдвэрлэлийн арга, аграр (газар) асуудлыг колони ба үндэсний асуудалтай холбож улмаар тэдгээр орнуудын нийгмийн хувьсгалын хувь заяанд хариу өгсөн хэрэг юм.

Англи нь Энэтхэгт ихээхэн хэмжээний лан мөнгийг Английн бараа таваар, үнэт цаас (вексель) борлуулах зэрэг замаар хуримтлуулж, түүгээрээ Энэтхэгээс хар тамхи авч Хятадад оруулах, Хятад, Энэтхэг (бенгал) торго авч Франц, Италид (лан мөнгөөр) худалдах зэрэг мөлжилгийн систем зонхилж байсныг К. Маркс «Капитал»-ынхаа Ш ботид иш баримтаар харуулсан байна.³ Энэ бол Марксын хэлснээр «үйлдвэрлэлийн капиталист эриний үүрийн туяа» бөгөөд залгаад Европын улсуудын худалдааны дайн газар сайгүй буцалсны нэг нь Хятадын эсрэг явуулсан «хар тамхины» дайн болно.

Манжийн эсрэг чиглэсэн Тайпины бослогыг Маркс эхэн үедээ шашны өнгө аястай байсан ба энэ нь бүх дорно дахины хөдөлгөөний нийтлэг шинж гээд хөдөлгөөний гол шалтгаан нь Хятадын хэрэгт Европ хөндлөнгөөс оролцох болсон, алт, мөнгө гадаадад урсан гарах болсон, гадаадын таваар, хар тамхи их оруулснаас эдийн засгийн тэнцвэр алдагдсан зэргээр тайлбарлаж, Хятадын ард түмэн тэмцэн боссонтой нь холбогдуулж К. Маркс, хар тамхи мансууруулахын хамт бас сэрээх үйлчилгээтэй байдаг нь сонин юм гэж бичиж байжээ.⁴

* — Бүгд найрамдах улс, Эрх чөлөө, тэгш байдал,

Ах дүүсэг ёс. — К. Маркс, Ф. Энгельс соч., т. 7, М, 1 1956, с. 234 * — Хятадын хувьсгалыг дарагч капиталист гүрнүүдийг зэмэлж В. И. Ленин хэд хэдэн өгүүлэл бичсэний дотор «Хоцрогдсон Европ, тэргүүний Ази» гэдэг алдарт өгүүл дээ 1913 оны 5-р сарын 31-нд нийтлүүлжээ.

Ийм «эсрэг тэсрэгийн нэгдэл» аль зэрэг түгээмэл зарчим гэдгийг соёл иргэншилт ертөнцөд Хятадын хувьсгалын үзүүлж байгаа нөлөө зураглан харуулах тухай К. Маркс онцлон тэмдэглэхдээ Европын ард түмний айсуу бослого, бүгд найрамдах улсын эрх чөлөө, удирдлагын арай хямд төсөр хэлбэрийн төлөө тэмцлийн ойртож байгаа үе шат юуны өмнө Оросын талаас биш харин Тэнгэрийн эзэнт улсад өнөө үед юу болж байгаагаас шалтгаална гэж үзэхэд хүрчээ.⁵ Тэрээр хар тамхийг хүчээр оруулсан Английн хөрөнгөтнүүдийн колончлолын эсрэг Хятадад арваад жил үргэлжилсэн бослого нэгдмэл нэг хүчирхэг хувьсгал болж хувирав гэж дүгнэж байв. Гэвч газарзүйн хувьд Маркс Дорнод гэдэг ойлголтод Орос орныг оруулж Орост гарах хувьсгал Ази, Дорнодахинд онцгой нөлөөлөх учиртайг ухаарч байжээ. Тэрээр «хувьсгал энэ удаа хувьсгалын эсрэг бэлтгэл арми, хөндөгдөөгүй бэхлэлт цайз болж байсан Дорнодод эхлэнэ» гэж бичиж байсан бол Ф. Энгельс «Орос бол өнөөгийн эрин зууны Франц бөгөөд нийгмийн шинэ өөрчлөн байгуулалтын хувьсгалт санаачлага түүнд хууль ёсоор ноогдоно» гэж үзсэн нь хэрэг дээр биелэгдсэн юм. Энэ нь Ази, Дорно дахинд хүчтэй нөлөөлсөн 1905—1907 оны Оросын ард түмний анхдугаар хувьсгал болно.

Японы болон олон улсын ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн С. Катаяма 1905 оны орос японы дайны үед эхэлсэн оросын 1905 оны хувьсгалын тухай өгүүлэлдээ «. . . XIX зууны эхээр Францын гүйцэтгэсэн үүргийг XX зууны эхээр Орос гүйцэтгэж байна. Өрнөд Европ дахь хувьсгал Францаас дохио хүлээдэг байсан шиг дорно дахины тонон дээрэмдүүлж дарлагдсан орнууд одоо Оросын хувьсгалын дохиог хүлээж байна» гэж хувьсгалыг талархан уриалж байлаа.

Оросын анхдугаар хувьсгалын цууриа Азийн ард түмний бүрэг бүдүүлэг байдлыг эцэс болгохын эхлэлт болж Лениний бичсэнчлэн дэлхийн капитализм, 1905 оны оросын хувьсгал хоёр Азийг бүрмөсөн сэрээж, дундат эртний үеийн зогсонги байдалд нухлуулан зэрлэгшсэн олон дүнчүүр хүн шинэ амьдрал, хүний хамгийн наадхан захын эрх чөлөө, ардчилалын төлөө тэмцэлд боссон билээ.

Дорнодахины хувьсгалт хөдөлгөөний явцад 1917 онд орос оронд ялсан аугаа их октябрийн социалист хувьсгалаас хойш чанарын асар их өөрчлөлт гарч тэдгээр орнуудад марксизм тууштай түгэн дэлгэрч ажилчин ангийн улс төрийн хөдөлгөөн 1920-иод оны эхээр эрс эрчимтэй урагшилж Дорнод ахины бараг бүх орнуудад ажилчин ангийн бие даасан намууд үүсэн байгуулагдлаа. Энэ үйл явцад Дорнод ахины ажилчин ангийн хөдөлгөөний олон улсын ач холбогдлыг бүр анхнаасаа өндөр үнэлж байсан коммунист интернационал Дорно дахины хувьсгалт хөдөлгөөний шинж чанарын тухай онолын үндэс боловсруулах зэргээр чухал үүрэг биелүүлсэн юм. Үнэндээ ч ажилчны хөдөлгөөн Дорнод ахинд өрнөсөөр л бүх дэлхийн пролетари нар коммунизмын тугийн дор нэгдэх түүхэн үйл явдал хэрэгжиж эхлэх байлаа.

Дэлхийн дайны дараа Азийн хэд хэдэн орон юуны өмнө Хятад, Вьетнам, Солонгост үндэсний чөлөөлөх хувьсгал ялсан явдал Дорно дахины ард түмэнд шинэ нийгмийг байгуулах замыг заагч марксизм ленинизмын түүхэн үнэний баталгаа боллоо. Дорнодахины орнуудын хөгжлийн өнөөгийн шатанд нийгмийн хувьсгалын асуудал түүний үндэсний хийгээд империализмын эсрэг агуулгатай нягт уялдаатай

өрнөж байна. Энэ байдлаас үүдэн Ази Номхон далайн бүс нутгийн энх тайван аюулгүй байдлыг ханган, цөмийн болон бүх төрлийн зэвсгийг устгах, улс төрийн шинэ сэтгэлгээ, хувьсгалт өөрчлөн байгуулалтын уур амьсгалыг нам төрийн бодлогод нэвтрүүлэх амьдралын шаардлага тулгарч байна.

БНХАУ-д баримталж буй социалист зам, ард түмний ардчилсан диктатур, коммунист намын удирдлага зэрэг дөрвөн гол зарчим нь өнөөгийн нөхцөлд социалист хувьсгалын тухай марксизм-ленинизмын сургаалд харшлагаасаа, харин уг сургаалын аугаа их амьдрах чадал, татах хүчийг миллиард гаруй хүн амтай энэхүү том гүрний жишээн дээр нотлон харуулж буй нь илүү байна. Хятадын нийгмийн социалист байгуулалтын өнөөгийн шатанд нэг хүнийг тахин шүтэхтэй холбогдсон адал балмад чиг шугам асар их гарч хохирол үзүүлсэн боловч Хятад дахь социализмын хувь заяаг бүхэлд нь гутааж баллаж чадсангүй. Орчин үеийн нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үзэл суртлын үндэс болж үл чадах харгис маоизм олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний зүгээс болон түүний бүрэлдэхүүнд багтаж байгаа ХКН-ын өөрийнх нь зүгээс зохих няцаалт авсныг бид мэднэ.

Хятадад өнөө хэр нь марксизмыг өөлөгчид, тэр ч байтугай үгүйсгэгчид байсаар боловч тэд дэлхий дахины ажилчин ангийн замыг гэрэлтүүлэгч уг сургаалаас ухралт хийснээ л харуулахаас биш түүнийг элээх, бөхөөх тавилангүй юм.

Марксын сургаалыг засварлах гэсэн оролдлого, практик дээр тохиолдох тактикийн зөрөлдөөн, тэр үндсэн дээр гардаг хагарал зэргийг ажилчин анги зүйрлэшгүй их хэмжээгээр бас зайлшгүй үзэж өнгөрүүлэх болно гэж В.И. Ленин «Марксизм ба ревоизинизм» гэдэг зохиол 100 бичжээ. Маркс Энгельс, Ленин нар социализмын зарчмыг онолын хувьд үндэслэхдээ ирээдүйн нийгмийн дүр зургийг нарийвчлан гаргахыг гол болгосонгүй. Тэгэх ч бололцоогүй байж. Ирээдүйн нийгэм нь бүх социалист улсуудын хувьсгалт бүтээлээс үүсч бүрэлдсэн ба тэгэж үүсэн бүрэлдэх нь одоо ч үргэлжилсээр байна.⁹ БНХАУ-ын нийгмийн хөгжилт энэ л хүрээнд багтаж байна. Өнгөрсөн оны сүүлчээр хуралдсан ХКН-ын ХШ их хурал Хятад орныг социализмын эхэн шатанд оршиж байгааг тодорхойлоод БНХАУ-ыг баян, хүчирхэг, ардчилсан, соёл иргэншилт орчин үеийн социалист улс болгон хувиргахын тулд тухайн шатанд хэрэгжүүлэх намын үндсэн чиг шугамыг боловсрууллаа. БНХАУ эдийн засгийн шинэчлэлтийг бүр 70-аад оны сүүлчээс эхэлсний хувьд одоо ялангуяа хөдөө аж ахуйн салбарт багагүй амжилт олж ашигтай дадлага туршлага бишгүй хуримтлагджээ. Мал, хөдөө аж ахуй, эдийн засгийн маань зарим салбар ижил төстэй манай улсад ч хөрш зэргэлдээ хятад орны тийм туршлагыг сонгон судалж ашигтайг нь өөрийн орны нөхцөлд тохируулан бүтээлчээр хэрэглэж болохгүй газаргүй юм.

Маркс Европын улс орнуудын улс төрийн түүхийн тоймыг судлахдаа тухайн орнуудын түүхтэй холбогдуулан X-XI зууны үеийн Египет Сирийн түүх, ХП-XI зууны үеийн Татар, XIV—XV зууны үеийн Түрэгийн түүхээр хөтөлсөн гар бичмэлийн дурсгал үлдээжээ. Марксын гар бичмэлийн нэг хэсэг буюу Энгельсийн нэрэлсэнээр «Он дараалсан тэмдэглэл»-ийн дөрвөн дэвтэрийн нэгдүгээр дэвтэрт буй Дорно дахины улсууд (1092—1291) гэсэн бүлгийн дотор «Чингис хаан», түүний хувүүд ба Ази дахь хамаатнууд (уг эхэд Ко буюу түншүүд гэсэн утгаар

авчээ -зох), Хорезмын улсын уналт, татарууд Европт аян дайн хийсэн нь, Чингис хааны үхсний дараах Монгол улс, Халифадын уналт, Перс, Сири, Египет гэсэн дөрвөн зүйлд Монголын феодалын нэгдсэн улсын ялангуяа байлдан дагуулалтын түүхийг зураглан харуулжээ. Тэрээр ялангуяа ХШ зууны Монголын түүхийг Шлоссер, Сегюр зэрэг Өрнөдийн болон Карамзин зэрэг оросын нэрт түүхчдийн бүтээлээр дамжуулан судалж Алтан Ордын улсын үеийн Өрнөд-Дорнодын худалдаа арилжаа, дайн байлдаан, эдийн засаг, соёлын бүхий л асуудлыг нягт нямбай судлан дүгнэжээ.

Дундад зууны үеийн Монголын ангит нийгэм, түүний эдийн засгийн бүтэц, хөгжилт, газар эдэлбэр, байлдан дагуулалт зэргийн талаар К. Марксын хийсэн судалгааны арга зүй, шинжлэх ухааны дүгнэлт, тэдгээрийн ач холбогдлыг манай эрдэмтэд өндөр үнэлдэг юм.¹¹ К. Маркс, Ф. Энгельс нар нийгмийн нэг формац нөгөөгөөр солигдох төдийгүй зарим формацийг алгасч болох тухай онолыг үндэслэж Өрнөд Европын орнуудад пролетари нар ялсны дараа, капиталист үйлдвэрлэлийн харилцаанд дөнгөж саяхан орсон бөгөөд омгийн ёс дэглэм буюу иймэрхүү зүйлийн үлдэгдэл хэвээр үлдсэн тийм орнуудад социалист нийгэмд хүрэх хөгжлийнхөө процессыг үлэмж богиносгож болох ба ингэж «хоцрогдсон орнууд хөгжлийнхээ процессыг богиносгох зам нь ... капитализмын өмнөх хөгжлийн шатанд байгаа бүх орнуудад хамаарах юм»¹² гэжээ. Энд яригдаж байгаа хөгжлийн процессийг богиносгох зам бол капитализмыг алгасч социализмд хүрэх зам гэдгийг марксизмыг үндэслэгчид ойлгож байсан төдийгүй тэрхүү товчилсон зам нь харьцангуй товч боловч хэд хэдэн үе шат дамжих түүхэн үйл явц гэдгийг урьдчилан харсан байна.

К. Маркс Ф. Энгельс нараас хоцрогдсон орнууд социалист байгуулалтанд хүртлээ дамжих нийгэм улс төрийн хэлбэр, үе шатыг В. И. Ленин тодруулж хоцрогдсон орнууд ялсан пролетари нарын орны тусламжтайгаар хөдөлмөрчин ард түмний диктатурын хэлбэрээр социализмд хүрэх үзэл санааг дэвшүүлсэн билээ. Тус бүр 20-иод жил үргэлжилсэн ардчилсан социалист хоёр шатыг дамжиж анд нөхөр агуу их ЗСБНХУ-ын зүйл бүрийн тус дэмжлэгтэйгээр хөдөлмөрчдийн төрийг бэхжүүлэх замаар капитализмыг алгасч социализмд хүрсэн БНМАУ-ын туршлага Марксизм, Ленинизмын сургаал, түүний үзэл санааны тод биелэл боллоо. БНМАУ-ын түүхэн замналын олон улсын ач холбогдол ч үүнд оршино. Энэ үзэл санааны биелэлтийг Ази Африкийн социалист чиг баримжааны орнуудын хөгжилт нэгэн адил харуулж байна.

Социалист хувьсгалын тухай К. Маркс, Ф. Энгельс нарын онолын үндэслэлийг бүхэлд нь буюу түүний дотор хөгжлийн капиталист бус замын тухай томъёололыг бүтээлчээр баяжуулсан ленинизмыг бид империализм буюу пролетарийн хувьсгалын үеийн марксизм гэж зүй ёсоор нэрлэдэг билээ. Марксизм, ленинизмын материалист диалектик, түүний үндсэнд тулгуурласан социалист хувьсгалын тухай гол гол концепцууд өнөө үед Ази, Африк, Латин Америкийн социалист болон хөгжиж байгаа олон орны эрх барих намуудын улс төрийн чиг баримжаа болсоор байна. Гэвч энэ бол марксизм, ленинизм, түүний гол цөм болох социалист хувьсгалын онол хөгжлийнхөө бүхий л үеийн турш ямар ч саад бэрхшээлтэй тулгаралгүй, шулуун дардан замаар явж ирсэн буюу явна гэсэн үг огт биш бөгөөд харин ч гадаад дотоодын

ревозинист, оппортунист, консерватив зэрэг элдэв янзын хэлбэрүүд империалист харгис хүчний ил далдын дайралт шахалтын нөлөөг гэтлэн давсаар ирсэн яруу алдарт түүхэн замналтай билээ.

АНУ-ын нийгэм судлаач Ричард Т. Лапиер бичихдээ «Марксыг дэлхийн хүн амын магадгүй гуравны нэг нь сайн дураараа ч бай, шаардлагаар ч бай коммунизмын эцэг, пролетари нарын аврагч, ХХ зууны зөн билэгч гэж хүндлэж түүний «Капитал» ном нь Орост Христосын судар, Хятадад Кунзийн сургаалыг албан ёсоор орлоод байгаа боловч Маркс өөрийн нэртэй холбогдох хожим ирээдүйн өөрчлөлтийн төлөв төрхийг урьдчилан хараагүй юм. ХХ зуунд гарсан хувьсгалууд Марксын бодсон шиг тогтвортой, тэгш нийгмийн системд хүргэсэнгүй. ... гэх зэргээр бичжээ.¹³

Тэр ч байтугай Маркс хуучирав, ЗХУ-д социалист нийгмийг Марксынхаар бус, Ленинийхаар байгуулав гэж Марксыг Лениний эсрэг тавих, Марксыг Энгельсийн эсрэг бүр Марксыг Марксын эсрэг сөргүүлэн тавих нийгэм судлаач, улс төрчид өрнөдөд гарсаар байна. Гэвч ийм зэмлэл бол гайхалтай биш юм. Капитализмыг хамгаалахын тулд марксизмыг муулах нь мэдээж хэрэг бөгөөд хөрөнгөтний үзэл сурталчид марксизмыг мэндэлсэн цагаас нь хойш харааж зүхсэн бөгөөд одоо бүтэн 140 гаруй жил хараасаар боловч марксизм ялан мандах чадалтай, хүчтэйгээ харуулсаар байна.

К. Маркс, Ф. Энгельс нарын «Коммунист намын тунхаг» анх хэвлэгдэх үед (1848) Европт хий үзэгдлийн чанартай байсан коммунизм өнөө үед дэлхий нийтийн чанартай үзэл санаа болж коммунистуудын холбоо анх 300—400 хүнтэй байгуулагдаж байсан бол эдүүгээ коммунист ажилчны намууд эгнээндээ таван живийн 100 гаруй орны 80 гаруй сая гишүүдийг нэгтгэж, В. И. Лениний үед дөнгөж сэргэж байсан Ази, Африкт одоо бараг 1,5 сая гишүүд бүхий коммунист, ажилчны 27 нам байгуулагдан тэдгээр орны ажилчин ангийг төлөөлж байна. Ази, Африкийн хөгжиж байгаа орнуудын ажилчин ангийн эгнээнд 200 сая гаруй хүн хамрагдаж тэр нь нийт ажилчин ангийн гуравны нэг шахам хувийг эзлэх боллоо.

Ази, Африк, Латин Америкийн хөгжиж байгаа орнуудын дотроос 150 сая хүн амтай 20 орчим орон хөгжлийн социалист чиг баримжаагаар урагшилж тэдний туршлага капиталист бус хөгжлийн тухай марксизм, ленинизмын үндсийг тавигчдын мэргэн сургаалын үнэн зөвийг нотолж байна.

Дорнодахины коммунист ажилчины намууд өөрсдийн эцэс туйлын зорилго, болох даян дэлхийн энх тайван, аюулгүй байдал, социализм, коммунизмын үйл хэргийн төлөө тэмцлээ тууштай үргэлжлүүлж байна. Энэ тэмцэл бол эрин үеийн хамгийн ариун шударга, эцсийн бүлэгт хорвоо ертөнц хүн төрөлхтний эсэн мэндийн төлөөний тэмцэл болно.

¹ К. Маркс, Ф. Энгельс. түүвэр зохиол 1-р боть, УБ., 1969 91 дэх тал

² К. Маркс, Ф. Энгельс, түүвэр зохиол, 1-р боть, УБ, 1969. 555 дахь тал

³ К. Маркс, Капитал т. III ч. I. П. М., 1955 с. 566-567, 606

⁴ К. Маркс, Ф. Энгельс, соч., т. 15, М., 1959 с. 529

⁵ К. Маркс, Ф. Энгельс. соч., т. 9 м., 1957. с. 98

⁶ К. Маркс и Ф. Энгельс, соч., т. 21, с. 490

⁷ Революция 1905—1907 годов. Документы и материалы, М, 1975, с. 348

⁸ В. И. Ленин, Арван хоёр боть түүвэр зохиол, М., 1987 6-р боть, 377 дахь тал

⁹ М. С. Горбачев. Перестройка и новое мышление для нашей страны и для всего мира. М., 1987 с. 168

¹⁰ Архив Маркса и Энгельса т. V л. 1938. с 219—232, т. VIII. л., 1946. с 147—154

¹¹ Н. Ишжамц, М. Пагма, К. Маркс монголын тухай «Дорнодахины судлалын асуудал» 1983. № 1 (8) УБ., 16—19 дэх тал, А. Минис. «Капитал» и некоторые аспекты аграрной проблемы в МНР — «Маркс и современность» М., 1968 с. 512

¹² К. Маркс, Ф. Энгельс түүвэр зохиол, II боть, УБ. 1970. 468 дахь тал

¹³ Richard T. La Piere. NY p. 519.

УЛС ТӨР, УЛСЫН БАЙДАЛ

ЗӨВЛӨЛТ-МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ АХ ДҮҮГИЙН БАРИЛДЛАГААНЫ ЭХ ҮҮСВЭР

Д. Б. УЛЫМЖИЕВ

Түүхийн ухааны доктор, профессор

Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улс шинэ амьдралыг цогцлон байгуулах найрамдал, хамтын ажиллагааны замаар нэгэнт 65 гаруй жил замнаж ирлээ. Зөвлөлт-Монголын харилцааны бүхий л түүх нь угтаа пролетарийн интернационализм, бүх үндэстэн ард түмэн эрх тэгш байх лениний үзэл санаа амьдралд хэрэгжин биелсэний түүх, тус хоёр орон дэлхийн түүхэнд анх удаа улс хоорондын харилцааны социалист хэв маягийн үлгэр дууриалыг үзүүлж дэлхийн социалист нөхөрлөлд цаашдынхаа хөгжлийг олсоны түүх мөн. Манай хоёр ард түмний найрамдал түүхийн гүн үндэс сурвалжтай бөгөөд мөнхүү үндэс нь октябрийн хувьсгалын ялалтаас бүр өмнө хаант Оросын дарлагч анги, хаант засгийн колонийн бодлоготой харгалдан буй болсон юм.

Хаант засгийн империалист бодлого нь Орос, Монголын Хөдөлмөрчдийн сайн хөршийн найрсаг харилцааг сааруулж чадаагүй билээ.

Ф. Энгельс, Орос нь Дорно дахинд дэвшилтэт үүрэг гүйцэтгэснийг өгүүлж байлаа. Үнэхээр ч Оросын гүйцэтгэх үүрэг түүнтэй хөрш зэр гэлдээ Гадаад Монголын хувьд онцгой ач холбогдолтой байсан нь илэрхий. XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн Орос-Монголын харилцааг бүхэлд нь судалсан зөвлөлт, Монголын эрдэмтэд өөрсдийн судалгаандаа,¹ хувьсгалын өмнөх Монголын эдийн засагт Оросын худалдааны капитал мөлжигч үүрэг гүйцэтгэж байсан хэдий ч Орос нь Монголын ард түмний аж ахуй, соёлын хөгжилд тодорхой дэвшилтэт үүргийг гүйцэтгэж байлаа гэж бодитойгоор тэмдэглэжээ. 1917 оны Октябрийн хувьсгал хүртэлх Орос-Монголын харилцааг тодорхойлох гол зүйл нь Оросын ард түмний феодалын Монголынхоос илүү өндөр соёлын нөлөө байлаа. Хаант Оросоос жич өөр Орос-Дэлхийд хамгийн хувьсгалч ажилчин анги, большевик нам бүхий Оросоос Монголд дэвшилтэт хувьсгалт үзэл санаа нэвтэрч байв.